



"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

- **Зээлийн үйл ажиллагаа** ————— 04 Зээлийн үйл ажиллагаа
05 Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд
- **Бизнесийн үйл ажиллагаа** ————— 06 Бизнесийн үйл ажиллагаа
- **Харилцагчийн үйл ажиллагаа** ————— 13 Харилцагчийн үйлчилгээ
- **Санхүүгийн үйл ажиллагаа** ————— 14 Санхүүгийн байдлын хураангуй тайлан
15 Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
- **Эрсдэлийн удирдлага** ————— 16 Эрсдэлийн удирдлага
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
- **Компанийн засаглал** ————— 17 Компанийн засаглал
18 Дотоод аудитын үйл ажиллагаа

ЛэндМН
хөрөнгөөр
баталгаажсан
үнэт цаас
гаргана

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Сайн байцгаана уу,
Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид,
хувьцаа эзэмшигчид, хамтрагчид,
харилцагчид та бүхэндээ энэ өдрийн
мэндийг хүргэе.

2022 оны III улиралд компанийн
цэвэр зээлийн багц өмнөх оны мөн
үетэй харицуулахад 53.4%-иар өсч
46.3 тэрбум төгрөгт, компанийн
нийт орлого өссөн дүнгээрээ 13.08
тэрбум төгрөгт хүрсэн буюу 47.0%-
иар өссөн, харин цэвэр ашиг 2.99
тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь
бидний бизнесийн цар хүрээ өсөн
нэмэгдэж буйг илэрхийлж байгаа
юм.

Бид 2022 оны III улиралд өөрийн
бүтээгдэхүүн болон аппликейшний
хөгжүүлэлтүүдээ үргэлжлүүлэн хийж
LendMN аппликейшний үндсэн
бүтээгдэхүүн болох Lend Зээл-
ийг ашигласан хугацаагаар хүүгээ
төлдөг болгон шинэчилсэнээс гадна
LendMN аппликейшний “Зээл”
цэсийг сайжруулан ашиглахад илүү
хялбар болголоо.

Мөн Lendauto- Эко автомашины
зээлийн үйлчилгээг өргөжүүлэн,
автомашины зээлийн эрхээ LendMN
аппликейшнээр тодорхойлуулан,
богино хугацаанд автомашинтай
болох боломжийг харилцагчдад

олгосноор харилцагчдын цаг
хугацааг хэмнэж ажиллажээ.
Хэдийгээр эдийн засаг тогтворгүй
байгаа ч ЛэндМН маань зээлийн
үйл ажиллагаагаа хэвийн явуулж
Улаанбаатар хот болон хөдөө орон
нутагт LendMN аппликейшний
зээлийн гэрээ байгуулах боломжийг
бүрдүүлэн ажилласанаар нийт
зээлийн гэрээт харилцагчийн тоо
одоогоор 194 мянгад хүрээд байна.
ЛэндМН-ийн хувьд 2022 оны III
улиралд нилээдгүй олон өдөрлөг,
арга хэмжээний ивээн тэтгэгч,
хамтран зохион байгуулагчаар
оролцжээ. Үүнээс дурдвал
Lend Pay- Худалдан авалтын
зээлийн үйлчилгээгээр Үндэсний
үйлдвэрлэлийг дэмжих “НААДАМ
ЭКСПО-2022” үзэсгэлэн худалдаа,
Next Electronics- той хамтран “Ur-
ban Expo”-д оролцож, залуучуудын
дунд хамгийн хүлээлт өндөртэй
байдаг “XMF REBORN ULAAN-
BAATAR 2022” хөгжмийн наадмын
албан ёсны дэмжигч байгууллагаар,
“НИЙСЛЭЛИЙН БИЗНЕС
ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ЧУУЛГА УУЛЗАЛТ” -нд хамтрагч
байгууллагаар ажиллажээ.
Үүнээс гадна бусад хамтын
ажиллагаатай байгуулагуудтай
хамтран харилцагчид зориулсан

хөтөлбөр, урамшууллуудыг зохион
байгуулсан байна.

Мөн энэ улирлын онцлох нэгэн үйл
явдал нь ЛэндМН нь хөрөнгийн
зах зээлд дахин шинээр үнэт цаас
гаргахаар болсон явдал юм. Үүний
хүрээнд “ЛэндМН Актив ТЗК” ХХК-
ийг үүсгэн байгуулсан бөгөөд тус
компани маань 2022 оны 09 дүгээр
сарын 21-ний өдөр Санхүүгийн
Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр
баталгаажсан үнэт цаас гаргах
зөвшөөрлөө авч, нийт 4.85 тэрбум
төгрөгийн Хөрөнгөөр баталгаажсан
үнэт цаас гаргахаар боллоо. Ийнхүү
татан төвлөрүүлсэн хөрөнгийг
ЛэндМН нь өөрийн өсөн нэмэгдэж
буй үйл ажиллагааны тэлэлт, мөн
дараа дараагийн шинэ бүтээгдэхүүн
үйлчилгээг гаргахад зарцуулах юм.

Ингээд нийт харилцагч, хувьцаа
эзэмшигч та бүхэндээ 2022 оны III
улирлын санхүү, үйл ажиллагааны
тайлангаа танилцуулж байна.

*Хүндэтгэсэн:
“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх
захирал Б.Удвал*




Зээлийн үйл ажиллагаа

✓ 2022 оны III улиралд нийт харилцагч нартаа 72.25 тэрбум төгрөгийн дүнтэй 342 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.


Түүнчлэн 2022 оны III улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2022 оны II улиралтай харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 1.4%, олгосон зээлийн тоо 2.9%, цэвэр зээлийн багц 10.5%-иар тус тус өссөн амжилттайгаар бид 2022 оны III улирлаа үдлээ.

2022 оны III улирлын үзүүлэлтүүдийг өмнөх II улиралтай харьцуулсан байдал


Гэрээт харилцагчийн тоо
(Өссөн дүнгээр, мянган харилцагчид)




Нийт олгосон болон сунгасан зээлийн тоо
(мянган зээл)



Нийт олгосон болон сунгасан зээлийн дүн
(тэрбум төгрөг)



Цэвэр зээлийн багц
(тэрбум төгрөг)





Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2022 оны III улирлын байдлаар чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 5.78% байгаа бөгөөд энэ улиралд зээлийн эрсдэлийн сангийн нөөц 3.43 тэрбум төгрөг буюу

зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг өмнөх улиралаас 5.1%-иар нэмэгдүүлж 119.3% хүргэж ажиллалаа.


Тэрбум төгрөг	2021.I	2021.II	2022.III
Нийт зээлийн багц	35.50	44.47	49.71
Зээлийн эрсдэлийн сан	(2.53)	(3.03)	(3.43)
Цэвэр зээлийн багц	32.97	41.44	46.28
Хэвийн зээл	32.13	40.82	45.49
Хугацаа хэтэрсэн зээл	1.05	1.00	1.34
Чанаргүй зээл	2.32	2.66	2.87
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	6.5%	5.98%	5.78%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	109.1%	114.2%	119.3%





Бизнесийн үйл ажиллагаа

Хувьцааны ханшын мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 оны III улирлын хаалтын байдлаар компанийн нэгж хувьцааны ханш 30 төгрөгөөр хаагдлаа.

2022 оны III улиралд:

Нийт арилжаалагдсан ширхэг – 2.35 сая ширхэг
Нийт арилжаалагдсан үнийн дүн – 73.95 сая төгрөг

Хувьцаа
эзэмшигчдийн
эзлэх хувь




7.6%

Халаасны
хувьцаа



17.4%

Олон нийт



75.0%

"Анд
Системс" ХХК



“ЛэндМН ББСБ” ХК 2022 оны эхний хагас жилийн тайлангаа танилцууллаа.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд наймдугаар сарын туршид 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд ил тод, нээлттэй танилцууллаа. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 15:00 цагт “ЛэндМН ББСБ”ХК-ийн

2022 оны эхний хагас жилийн тайланг тус компанийн Гүйцэтгэх захирал Б.Удвал Монголын хөрөнгийн биржийн байранд танилцууллаа.

https://ikon.mn/n/2mw8?fbclid=IwAR044Lqh23YffBFx-rU18ahDSI5_aXCulhppyu21ww5RNsvjEEuAcMOuwZ7I





2021 оны 06-р сарын 30-ний өдөр арилжаалсан
"ЛЭНДБОНД"-ийн Өгөөж

2022.07.01-ний өдөр үнэт цаасны дансанд байршлаа

"ЛЭНДБОНД"-ийн өгөөж 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр үнэт цаасны дансанд байршлаа.

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр арилжаалсан "ЛЭНДБОНД"-ийн өгөөж 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр үнэт цаасны дансанд байршлаа.

- Харилцагч та "ЛЭНДБОНД"-ын өгөөжөө өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан аваарай.
- Хэрвээ та SuperUp аппликейшнээр "ЛЭНДБОНД" захиалан авсан бол Rhinos Investment UTsK LLC үнэт цаасны компанийн 7510-0575 дугаарт хандаарай.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд
 #СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав





Lendзээл – Ашигласан хугацаагаараа хүүгээ төлдөг боллоо.

50 мянга – **4** сая хүртэл
Зээлийн эрх

30 хоног хүртэл
Хугацаа



LendMN аппликэйшний “Миний зээл” хэсэг шинэчлэгдэж, илүү хялбар боллоо



21 аймаг, 9 дүүрэгт

Гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.





Бензин бага зарцуулдаг
Байгальд ээлтэй автомашинаа
LendMN-ээс...

15% урьдчилгаа | **48 сар** хугацаа

2.5-2.9% хүү

30 сая хүртэл зээлийн хэмжээ

Lend Auto-Эко автомашины зээлийг LendMN-ээс...

LendMN аппликейшнээр автомашины зээлийн эрх үүссэн бол Бензин бага зарцуулдаг, Байгальд ээлтэй Toyota Aqua, Prius 30, Prius 40, Prius 41, Sai зэрэг /Hybrid/ автомашинуудаас сонголтоо хийгээд LendMN-ийн зээлээр худалдан авах боломжтой.

#АжлааАмжуул

#АжлааАмжуул

*Ахлаж байхдаа ч
Автомашины зээлийн
эрхээ талгаарай.*

2.5%-2.9%
Хүү

15%-с дээш
Урьдчилгаа

48
Сар хүртэл

lendauto
Эко автомашины зээл

Download on the App Store | GET IT ON Google Play

LendMN → "Зээл" цэс → "Автомашины зээл" → "Зээлийн эрх тооцоолох"



Шууд авья, хувааж төлье

Урьдчилгаагүй, хүүгүй, 60 хоногийн хугацаанд 4 хувааж төлөх нөхцөлтэй худалдан авалтын зээлийн үйлчилгээ болох Lendpay үйлчилгээг ЛэндМН-ий зээлийн эрхтэй харилцагч нар маань Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн (Эрдэнэт хот) хамтын ажиллагааны гэрээтэй худалдаа үйлчилгээний байгууллагуудаас авах боломжтой болж байна

ЛэндМН нь хамтрагч байгууллагуудтайгаа хамтран LendPay үйлчилгээний урамшууллын хөтөлбөрийг харилцагч нартаа сар бүр тогтмол санал болгож байна.

2 сая хүртэл

Зээлийн эрх

0

урьдчилгаа
шимтгэл
хүү

60 хоногт
4 хувааж төлөөрэй




Төлбөрөө ЛэндМН-ийн зээлийн эрхээрээ урьдчилгаа, шимтгэлгүйгээр шууд авсад, хувааж төлье



LendPay-Шууд авья, Хувааж төлье

“НААДАМ ЭКСПО-2022” үзэсгэлэн худалдаанд Lendpay үйлчилгээгээр оролцлоо

Үндэсний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, шинэ аж ахуйн нэгж, бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах, наадмын бэлтгэлээ нэг дороос үйлдвэрийн үнээр хямдралтай, урамшуулалтай үнээр худалдан авах бололцоог бүрдүүлдэг тус үзэсгэлэн худалдаанд ЛэндМН нь Lendpay үйлчилгээгээрээ хамтын ажиллагаатай байгууллагуудаа дэмжин оролцлоо.



“Нийслэлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”

Нийслэлийн Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Холбоо, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар-аас зохион байгуулсан жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон бизнес санаагаа хөгжүүлэх зорилготой эмэгтэйчүүдийг дэмжих арга хэмжээнд нийгмийн хариуцлагын хүрээнд ивээн тэтгэгч байгууллагаар оролцлоо.

“Urban expo” үзэсгэлэн худалдаанд Lendpay үйлчилгээгээр хамтран ажиллалаа

Next electronics-оос жил бүр зохион байгуулдаг “Urban expo” үзэсгэлэн худалдаанд Lendpay үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгож Lendpay үйлчилгээний давуу талуудыг сурталчлан оролцлоо.



MSM Бетастар ХХК-тай хамтарсан өдөрлөг зохион байгуулж лэндмн-ий бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулав

MSM Бетастар ХХК-ны байнгын харилцагч байгууллагуудын удирдах түвшний зочдод Бизнесийн цахим зээлийн бүтээгдэхүүн болон ЛэндМН-ий бусад бүтээгдэхүүн үйлчилгээг танилцууллаа




XMF – Хуур Music Festival-д LendMN “Пуужиндий” уриатайгаар оролцлоо.



Залуучуудын дунд хамгийн хүлээлт өндөртэй байдаг XMF REBORN ULAANBAATAR 2022 6000 үзэгчтэй хөгжмийн наадамд залуусын соёлыг дэмжин албан ёсны дэмжигч байгууллагаар хамтран ажиллалаа. Хөгжмийн наадмын

үеэр LendMN-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг таниулан сурталчилж, залуучуудад санхүүгээ зөв удирдах талаар мэдээлэл өглөө.



Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 20 ажилтантайгаар ажилласан ба 2022 оны III улирлын турш нийт 102,780 удаагийн харилцагчийн асуудлыг дуудлагын төв, сошиал суваг болон харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулан хүлээн авч тэдгээрийн 95,4%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан

асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. 2022 оны 3 дугаар улиралд дуудлагын төвөөр нийт 80,565 дуудлага хүлээн авч зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаарх мэдээллийг харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай хүргэн ажиллажээ.

Харилцагчийн үйлчилгээ

2022 оны III улиралд хүлээн авсан

80,565

нийт дуудлага

15 секунд

хүлээлгийн түвшин

Үйлчилгээ %

95.4

амжилттай хүргэсэн

Сошиал суваг болон

22,215

үйлчилгээний заалаар үйлчилсэн



Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны III улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 51.99 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 46.28 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 2.34 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 27.46 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 24.53 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 13.21 тэрбум төгрөг байна.

2022 оны III улирлын гол үзүүлэлтүүд

Нийт актив
51.99
тэрбум төгрөг

Нийт орлого
13.08
тэрбум төгрөг

Цэвэр ашиг
2.99
тэрбум төгрөг

Цэвэр зээлийн багц
46.28
тэрбум төгрөг

Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2022.I /Аудитлагдаагүй/	2022.II /Аудитлагдаагүй/	2022.III /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.70	2.02	2.34
Зээлийн багц (цэвэр)	32.97	41.44	46.28
Бусад хөрөнгө	1.81	1.77	2.27
Үндсэн хөрөнгө	0.82	0.74	0.69
Биет бус хөрөнгө	0.44	0.42	0.41
Нийт хөрөнгө	40.74	46.40	51.99

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2022.I /Аудитлагдаагүй/	2022.II /Аудитлагдаагүй/	2022.III /Аудитлагдаагүй/
Өр төлбөр	18.28	23.16	27.46
Эх үүсвэр	15.31	20.37	24.59
Бусад өглөг	2.97	2.79	2.87
Эздийн өмчийн дүн	22.46	23.23	24.53
Хувьцаат капитал	8.48	8.48	8.48
Хоёрдогч өглөг	2.85	2.85	2.84
Хуримтлагдсан ашиг	11.14	11.91	13.21
Нийт өр төлбөр болон эздийн өмч	40.74	46.40	51.99

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны III улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ өссөн дүнгээрээ 13.08 тэрбум төгрөг, өссөн дүнгээр 2.99 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2022.I	2022.II	2022.III
Нийт орлого	3.80	4.35	4.93
Хүүгийн зардал	(0.85)	(0.95)	(1.21)
Цэвэр орлого	2.95	3.40	3.72
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.35)	(0.49)	(0.40)
Үйл ажиллагааны цэвэр орлого	2.60	2.91	3.32
Удирдлагын болон ҮА-ны зардал	(1.55)	(2.02)	(1.87)
Татварын өмнөх ашиг	1.05	0.89	1.45
Татварын зардал	(0.12)	(0.12)	(0.16)
Цэвэр ашиг	0.93	0.77	1.29



Шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг өссөн дүнгээр (тэрбум төгрөг)





Эрсдэлийн удирдлага

“ЛэндМН ББСБ” ХК нь зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдөн ажиллаж байгаа төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна. 2022 оны III улиралд холбогдох журмуудыг дотоод үйл ажиллагаа болон хуулийн

шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Биет бус мэдээллийг нөөцлөх, нөхөн сэргээх журам, Ялгаварлал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх журам гэх мэт болно.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах,

активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны III улиралд 1.89 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.43 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар

тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 119.3%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. 2022 оны III улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2022.I	2022.II	2022.III
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.5%	41.6%	38.1%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	53.2%	47.3%	43.1%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.2%	43.9%	41.7%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	25.8%	8.7%	8.5%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-11.0%	-10.0%	-19.7%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	35.5%	37.1%	45.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	32.6%	44.5%	42.4%



Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, нэмэгдүүлэх, компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлздэг төдийгүй Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж, сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлж ажилладаг.

Манай компани нь 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМНББСБ”ХК-ийнТөлөөлөнудирдахзөвлөл(цаашид “ТУЗ”) нь 2022 оны III улиралд ээлжит 1, ээлжит бус 2 удаа хуралдав. ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрүүдийг холбогдох журамд заасны дагуу Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлуудаас тоймлон хүргэвэл:

- 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн ээлжит хурлаар Охин компани “ЛэндМН Актив ТЗК” ХХК-тай холбоотой асуудлууд, компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.
- 2022 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр эчнээ санал хураалтаар Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагууд болон компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.
- 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр эчнээ санал хураалтаар “ЛэндМН Актив ТЗК” ХХК-аас гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөл, байгуулах гэрээнүүдийн талаар тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна:

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Б.Итгэл, гишүүдээр С.Энх-Амгалан, В.Баярсайхан, Д.Галхүү, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар ажиллаж байгаа бол ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Ж.Жаргалсүрэн, гишүүдээр С.Боргил, О.Болдбаатар харин ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр



дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны даргаар С.Энх-Амгалан, гишүүдээр С.Боргил, Д.Галхүү нар тус тус ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Аудитын хороо нь 2022 оны III улиралд тус бүр 1 удаа буюу 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хуралдаж, компанийн үйл ажиллагаа, эх үүсвэр, дотоод аудиторын дүгнэлт, компанийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагуудын тухай хэлэлцсэн байна.

Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитын тогтолцоо: “ЛэндМН ББСБ” ХК нь Хамгаалалтын гурван бүс /Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулан ажилладаг.

Дотоод аудитын тогтолцоог харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар хамгаалалтын бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнаж, Гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.



ВЕБСАЙТ:
www.lend.mn

УТАС:
7707-0101

ИМЭЙЛ:
board@lend.mn